МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2017.07.17 № 2/2708

танай ____________-ны № ____________-т

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗАР, ТӨВ ЭМНЭЛЭГ
ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВИЙН
ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Салбарын жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө Эрүүл мэндийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 16-ны А/274 дугаар тушаалаар батлагдсаныг хавсралтаар хүргүүлж байна.

Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хавсралт 15 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Д.ОЧИРБАТ

083820

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 16 өдөр          Дугаар А/274          Улаанбаатар хот

## Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.1, 13 дугаар зүйлийн 13.1, 19 дүгээр зүйлийн 19.1.1, 19.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар батлсугай.

2. Эрүүл мэндийн салбарын жендэрийн эрх тэгш байдлыг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/-т даалгасугай.

3. Эрүүл мэндийн салбарын жендэрийн эрх тэгш байдлыг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг байгууллага, орон нутгийн түвшинд зохион байгуулах, шаардагдах санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрт тусгах, удирдлагын багийн нэг гишүүний ажил үүргийн хуваарьт жендэрийн асуудал хариуцах үүрэг хүлээлгэж албажуулан, тайланг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор ирүүлж ажиллахыг төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн орлогч дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

САЙД          А.ЦОГЦЭЦЭГ

080876

Эрүүл мэндийн сайды
2017 оны 07 сарын 16-ны өдрий
А/274 дугаар тушаалын хавсрал

# Эрүүл мэндийн салбарын жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө

**Зорилго:** Жендэрийн үзэл баримтлалыг эрүүл мэндийн салбарын бодлого, төсвийн төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх, хүний нөөцийг чадавхижуулах замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, мэдээлэл, сургалт сурталчилгааг жендэрийн мэдрэмжтэй болгох ажлыг эрчимжүүлж "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай" хууль, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оршино.

**Хугацаа:** 2017-2020

| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Хэрэгжих хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1.** Эрүүл мэндийн салбарын бодлого, хөтөлбөр, төсвийн төлөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй болгох, хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах<br><br>**Хүрэх үр дүн**<br>Эрүүл мэндийн салбарын хөгжлийн бодлого, төсвийн төлөвлөлт жендэрийн мэдрэмжтэй болж, хүний нөөц чадавхижсан байна. | | | | | | |
| 1.1 | Эрүүл мэндийн салбарын бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал, жендэрийн дүн шинжилгээний чиглэлээр | Сургалтад хамрагдсан бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид | Сургалтын удирдамж, төсөв, хөтөлбөр<br><br>Зохион байгуулсан | ЭМЯ<br>Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар | АХБ-ны ЭМСХХ<br>НҮБХАС<br>ДЭМБ | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | нөлөөллийн шаталсан сургалт зохион байгуулах | | сургалтын тайлан<br><br>Сургагдсан хүний тоо | Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд | | |
| 1.2 | Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар болон төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн бүтцэд жендэрийн мэргэжилтний чиг үүргийг бий болгож, ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд тусгах | Жендэрийн асуудал хариуцсан эрүүл мэндийн ажилтан, мэргэжилтнүүд | Жендэрийн асуудал хариуцсан эрүүл мэндийн ажилтан, мэргэжилтнүүдтэй ЭМБ-ын тоо | Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар<br>Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд | ЭМЯ | 2017-2018 |
| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Хэрэгжих хугацаа |
| 1.3 | Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар болон төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн жендэрийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтад хамруулах | Сургагдсан мэргэжилтнүүд | Сургалтын тайлан | ЭМЯ<br>АХБ-ны ЭМСХХ төсөл | Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар<br>Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд | 2018 |
| 1.4 | Эрүүл мэндийн салбарын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөнд жендэрийн дүн шинжилгээ хийх | Жендэрийн дүн шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ | Жендэрийн дүн шинжилгээ, үнэлгээний тайлан, зөвлөмж | ЭМЯ<br>ЭМХТ | АХБ-ны ЭМСХХ<br>Олон улсын байгууллага (ОУБ)<br>Төрийн бус байгууллага (ТББ) | 2017-2018 |
| 1.5 | Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнууд болон | Үнэлгээний тайлан, | Үнэлгээний тайлан Шинэчлэгдсэн | ЭМЯ<br>АШУҮИС | АХБ-ны ЭМСХХ | 2018 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн төгсөлтийн дараах албан болон албан бус сургалтын хөтөлбөрт тойм үнэлгээ хийж, жендэрийн асуудлыг тусгах | зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, сургалтын хөтөлбөр | сургалтын хөтөлбөр | | НҮБХАС<br>ДЭМБ<br>ТББ | |
| 1.6 | Эрүүл мэндийн салбарын санхүү, хөрөнгө оруулалтын газрын ажилтнуудад жендэр, жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлт, жендэрийн чиг баримжаатай нөөц хуваарилалтын асуудлаар сургалт зохион байгуулах | Сургагдсан ажилтнууд | Сургалтын удирдамж, төсөв, хөтөлбөр<br><br>Зохион байгуулсан сургалтын тайлан<br><br>Сургагдсан хүний тоо | ЭМЯ<br>Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар<br>Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд | АХБ-ны ЭМСХХ<br>ДЭМБ | 2017-2020 |
| 1.7 | Малчин өрхийн гишүүд, эх, нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хүн хүчний болон санхүүгийн нөөцийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, хуваарилах арга зүйг нэвтрүүлэх | Хүн хүчний болон санхүүгийн нөөцийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, хуваарилах талаар хийсэн үйл ажиллагаа | Үйл ажиллагааны тайлан | ЭМЯ | Аймаг, нийслэлийн ЭМГ | 2017-2020 |

**Зорилт 2**. Эрүүл мэндийн салбарын бодлого, бүтэц, үйл ажиллагаанд жендэрийн дүн шинжилгээ, үнэлгээ, аудит хийх арга зүйг нэвтрүүлэх
**Хүрэх үр дүн**
Эрүүл мэндийн салбарын бодлого, бүтэц, үйл ажиллагаанд жендэрийн дүн шинжилгээ, үнэлгээ, аудит хийх арга зүй нэвтэрсэн байна.

| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Хэрэгжих хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| 2.1. | Эрүүл мэндийн салбарын бодлого, бүтэц, үйл | Дүн шинжилгээ, үнэлгээ, аудитын | Үйл ажиллагааны удирдамж, төсөв | ЭМЯ | АХБ-ны ЭМСХХ төсөл | 2018 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагаанд жендэрийн дүн шинжилгээ, үнэлгээ, аудитыг мэргэшсэн шинжээчийн оролцоотой хийж, жендэрийн асуудлыг бодлого, үйл ажиллагаанд тусгах санал, зөвлөмж гарган хэрэгжүүлэх | дүгнэлт, зөвлөмж | Гэрээ<br>Үйл ажиллагааны тайлан | | Жендэрийн асуудлаар мэргэшсэн ТББ | |
| 2.2 | Байгууллагын болон үйл ажиллагааны түвшинд жендэрийн дүн шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэх | Жендэрийн дүн шинжилгээ, үнэлгээ хийх чадавхи бүхий эрүүл мэндийн ажилтан, мэргэжилтнүүд | Сургалтын удирдамж, төсөв, хөтөлбөр<br><br>Зохион байгуулсан сургалтын тайлан<br><br>Сургагдсан хүний тоо | ЭМЯ<br>Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд<br>Аймаг, нийслэлийн ЭМГ | АХБ-ны ЭМСХХ төсөл<br>ОУБ<br>ТББ | 2018 |
| 2.3 | Хүйсээр болон нийгэм, эдийн засгийн байдлаар ангилсан тоон мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, дүн шинжилгээ хийж, тайлан, мэдээнд тусгаж байх | Хүйсээр болон нийгэм, эдийн засгийн байдлаар ангилсан тоон мэдээллийн нэгдсэн сан | Эрүүл мэндийн сайдын тушаал | ЭМЯ<br>ЭМХТ | Аймаг, нийслэлийн ЭМГ<br>Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд<br>ОУБ | 2018-2020 |
| 2.4 | Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа олон улсын байгууллагуудын төсөл, хөтөлбөрийн хүрээнд жендэрийн чиглэлээр хийгдсэн үйл ажиллагаа, судалгааны үр дүн, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх, хүний нөөцийг | Чадавхи бүхий хүний нөөц<br><br>Нэвтрүүлсэн дэвшилтэт арга зүй | Эрүүл мэндийн сайдын тушаал | ЭМЯ<br>Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд<br>Аймаг, нийслэлийн ЭМГ | АХБ-ны ЭМСХХ төсөл<br>НҮБХАС<br>ДЭМБ | 2018-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | зөв ашиглах, бий болгосон шинэ, дэвшилтэт арга зүйг эрүүл мэндийн байгууллагад нутагшуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх | | | | | |
| 2.5 | Улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхлэгч, гар аргаар ашигт малтмал олборлож байгаа иргэн, малчид болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийг эрсдлээс хамгаалах үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийх | Жендэрийн дүн шинжилгээний | Жендэрийн дүн шинжилгээний тайлан | ЭМЯ<br>АХБ-ны ЭМСХХ төсөл | ОУБ<br>ТББ | 2017-2020 |
| 2.6 | Эрүүл мэндийн чиглэлийн судалгаанд жендэрийн, нийгэм эдийн засгийн, соёл уламжлалын хүчин зүйлсийг судлаж, дүгнэлт, зөвлөмжийг үйл ажиллагаанд тусган, хэрэгжүүлэх | Жендэрийн, нийгэм эдийн засгийн, соёл уламжлалын хүчин зүйлсийг судлаж, дүгнэлт, зөвлөмж гаргасан судалгаа | Судалгааны тайлан | ЭМЯ<br>Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд<br>Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар | ОУБ<br>ТББ | 2017-2020 |

**Зорилт 3.** Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн биологийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн, жендэрийн мэдрэмжтэй болгож сайжруулах

**Хүрэх үр дүн**

Хүн амын бүлгийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний ээлтэй байдал сайжирсан байна.

| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Хэрэгжих хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| 3.1. | Үйлчлүүлэгчдийн ажил, | Үйлчилгээний | Үйлчилгээний | ЭМЯ | Аймаг, | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | амьдралын бодит нөхцөл байдал, хэрэгцээнд нийцүүлэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цагийн хуваарийг уян хатан болгох | цагийн хуваарийг үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчдэд ээлтэй байдлаар зохицуулан үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн байгууллага | цагийн хуваарийг үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчдэд ээлтэй байдлаар зохицуулсан тушаал, журам, шийдвэр | Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд<br>Аймаг, нийслэлийн ЭМГ | нийслэлийн ЗДТГ | |
| 3.2. | Хөдөөгийн хүн ам, төвөөс алслагдсан оршин суугчид, улирлын шинжтэй ажил хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан эрүүл мэндийн явуулын тусламж, үйлчилгээг өргөжүүлэх | Төрөлжсөн нарийн мэргэжлийн явуулын үйлчилгээ | Явуулын үйлчилгээний тоо, нарийн мэргэжлийн үйлчилгээний нэр төрөл | ЭМЯ<br>Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд | Аймаг<br>Нийслэлийн эрүүл мэндийн газар | 2017-2020 |
| 3.3. | Сумын эрүүл мэндийн төв, аймгийн нэгдсэн эмнэлгийн дэргэдэх эхийн амрах байрыг үйлчлүүлэгч, тэдний ар гэрийнхэнд ээлтэй байдлаар тохижуулж, үйлчилгээний чанарыг сайжруулах | Амрах байрны үйлчлүүлэгчээ дээдэлсэн үйлчилгээ | Шаардлага хангаж ажиллаж байгаа эхийн амрах байруудын тоо<br><br>Амрах байраар үйлчлүүлэгчдийн тоо | ЭМЯ<br>ЭХЭМҮТ | Аймаг, нийслэлийн ЭМГ<br>НҮБХАС ДЭМБ | 2017-2020 |
| 3.4 | Нөхөн үржихүйн дараахь насны хүмүүст зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх | Нөхөн үржихүйн дараахь насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн өвөрмөц тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхи бүхий эмч мэргэжилтнүүд | Сургалт үйл ажиллагааны тайлан<br><br>Эрүүл мэндийн сайдын тушаал<br><br>Чадавхи бүхий эмч мэргэжилтнүүдийн | ЭМЯ<br>Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд<br>Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар | ОУБ<br>ТББ | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Эрүүл мэндийн өвөрмөц тусламж, үйлчилгээ авах цэг | тоо<br><br>Эрүүл мэндийн өвөрмөц тусламж, үйлчилгээ авах цэгийн тоо | | | |
| 3.5 | Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх эмч, мэргэжилтэнг үе шаттай сургаж бэлтгэх | Чадавхи бүхий мэргэжилтнүүд | Сургалтын удирдамж, төсөв, сургалтын хөтөлбөр<br><br>Зохион байгуулсан сургалтын тайлан<br><br>Сургагдсан хүний тоо | ЭМЯ<br>ЭМХТ<br>АШУҮИС | Аймаг, нийслэлийн ЭМГ,<br>Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд | 2017-2020 |
| 3.6 | Аймаг дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд эрэгтэйчүүдийн кабинетыг ажиллуулж, үйлчилгээний стандарт, журмыг шинэчлэн мөрдүүлэх | Зорилтот бүлгийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй кабинет | Эрүүл мэндийн сайдын тушаал<br><br>Шинэчлэгдсэн стандарт, журам | ЭМЯ | Аймаг, нийслэлийн ЭМГ | 2017-2020 |
| 3.7 | Зорилтот бүлгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үнийг хөнгөвчлөх асуудлыг судлан шийдвэрлэх | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үнийн судалгаа | Судалгааны тайлан | ЭМЯ<br>ОУБ | Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд<br>Аймаг, нийслэлийн ЭМГ | 2017-2020 |
| **Зорилт 4.** Эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зорилтот бүлгийн нас, хүйсийн онцлог хэрэгцээ, зан үйл, хөдөлмөр эрхлэлт, шашин шүтлэг, итгэл үнэмшил зэргийг харгалзан жендэрийн мэдрэмжтэй зохион байгуулах | | | | | | |

**Хүрэх үр дүн**
Эрүүл мэндийн боловсрол, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй зохион байгуулах чадавхи нэмэгдсэн байна.

| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Хэрэгжих хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| 4.1 | Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл, сургалт сурталчилгааг жендэрийн мэдрэмжтэй болгох гарын авлагыг шинжээч мэргэжилтнүүдийн дэмжлэгтэй боловсруулан, хэвлүүлж бүх шатны эмнэлгийн удирдах ажилтан болон эмч мэргэжилтнүүдэд түгээх | Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл, сургалт сурталчилгааг жендэрийн мэдрэмжтэй болгох талаар гарын авлага | Гарын авлага боловсруулж, хэвлүүлсэн үйл ажиллагааны тайлан<br><br>Түгээлт хийсэн хуваарь | ЭМЯ<br>НЭМҮТ<br>Жендэрийн асуудлаар мэргэшсэн ТББ | ДЭМБ<br>АХБ-ны<br>ЭМСХХ төсөл<br>НҮБХАС | 2018-2019 |
| 4.2 | Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны материал, нийтлэл, нэвтрүүлгийг жендэрийн мэдрэмжтэй болгох онол, арга зүйн сургалтад үйлчилгээ үзүүлэгчдийг хамруулах | Сургагдсан мэргэжилтнүүд | Сургалтын удирдамж, төсөв, сургалтын хөтөлбөр<br><br>Зохион байгуулсан сургалтын тайлан<br><br>Сургагдсан хүний тоо | ЭМЯ<br>Жендэрийн асуудлаар мэргэшсэн ТББ | ХНХЯ<br>Жендэрийн үндэсний хорооны ажлын алба<br>АХБ-ны<br>ЭМСХХ төсөл<br>НҮБХАС<br>ДЭМБ | 2018-2020 |
| 4.3 | Эрүүл мэндийн боловсрол олгох эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй зохион байгуулахад олон нийтийн бүлэг, нийгмийн сүлжээ, төрийн бус байгууллагын | Хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөө | Үйл ажиллагааны тайлан | ЭМЯ<br>НЭМҮТ<br>Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд<br>Аймаг, | Олон нийтийн бүлэг, нийгмийн сүлжээ, төрийн бус байгууллага<br>ОУБ | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | оролцоог нэмэгдүүлж хамтын ажиллагааг өргөжүүлэх | | | нийслэлийн ЭМГ | | |
| 4.4 | Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт сурталчилгааг эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн жендэрийн үүрэг, хүйсийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн явуулах ажлыг орон нутгийн байгууллагуудын оролцоотой зохион байгуулах | Зохион байгуулсан үйл ажиллагаа | Мэдээлэл сургалт сурталчилгааны тайлан | Аймаг, нийслэлийн ЭМГ | НЭМҮТ | 2017-2020 |
| 4.5 | Гэр бүл төлөвлөлтийн талаар боловсрол олгох нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэн эмч, мэргэжилтний ур чадварыг сайжруулах, иргэдийн насны онцлогт тохирсон мэдээлэл, сурталчилгаа хийх | Сургагдсан эмч, мэргэжилтнүүд<br><br>Мэдээлэл сургалт сурталчилгааны материал | Үйл ажиллагааны тайлан | ЭМЯ<br>НЭМҮТ<br>НҮБХАС<br>ТББ | Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд<br>Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар | 2017-2020 |
| 4.6 | Эрүүл мэнд, нөхөн үржихүй, ялангуяа бэлгийн боловсрол олгох хичээлийн агуулгыг насны болон жендэрийн хувьд өвөрмөц хэрэгцээт бүлгийн онцлогт тохируулан боловсруулж, ерөнхий боловсролын сургуульд албан сургалтаар, их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт сонгон судлах хичээлийн хөтөлбөрт оруулах | ЕБС-ийн албан сургалтын хөтөлбөр<br>Их, дээд сургуулийн сонгон сургалтын хөтөлбөр | Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал<br><br>Үйл ажиллагааны тайлан | ЭМЯ<br>НЭМҮТ<br>НҮБХАС<br>НҮБХС | БСШУСЯ | 2017-2020 |
| 4.7 | Эрэгтэй, эмэгтэй хүмүүс, өсвөр насны охид, хөвгүүдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн | Өсвөр, үе, залуучуудад ээлтэй үйлчилгээ үзүүлж буй нэгж, | Үйл ажиллагааны тайлан<br><br>Өсвөр, үе, | ЭХЭМҮТ<br>НЭМҮТ | Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд | 2017-2020 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг тэдний оролцоотой хамтран төлөвлөх, хэрэгжүүлэх орчин бүрдүүлж, үйлчилгээ үзүүлэгчдийн ур чадварыг дээшлүүлэх | байгууллага<br><br>Сургагдсан эрүүл мэндийн ажилтнууд, нийгмийн ажилтнууд үйлчилгээ үзүүлэгчид<br><br>Үе тэнгийн сургагч нар | залуучуудад ээлтэй үйлчилгээ үзүүлж буй нэгж, байгууллагын тоо<br><br>Сургагдсан үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн ажилтнууд, нийгмийн ажилтнуудын тоо<br><br>Үе тэнгийн сургагчийн тоо | | ХНХЯ<br>Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар<br>ДЭМБ<br>НҮБХАС<br>НҮБХС | | |
| 4.8 | Хүн амын дунд зохиох мэдээлэл, сурталчилгааны болон зан үйлийг өөрчлөх мэдээлэл харилцааны ажилд улс төр, урлаг, соёл, спорт, шашны алдартнуудыг оролцуулан, тэднээр дамжуулан сурталчилгааг хүргэх ажлыг зохион явуулах | Улс төр, урлаг, соёл, спорт, шашны алдартнуудыг оролцуулан зохион байгуулсан мэдээлэл сурталчилгааны кампанит ажил | Мэдээлэл сурталчилгааны кампанит ажлын тайлан | НЭМҮТ<br>Аймаг, нийслэлийн ЭМГ<br>Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд | АХБ-ны ЭМСХХ төсөл<br>НҮБХАС<br>ДЭМБ | 2017-2020 | |
| 4.9 | Жендэрийн хэвшмэл ойлголт түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлийг үнэлж, хэвшмэл ойлголтыг халах, өөрчлөх чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны өргөжүүлсэн үйл ажиллагааг зохион байгуулах | Жендэрийн хэвшмэл ойлголт түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлийг үнэлж, хэвшмэл ойлголтыг халах, өөрчлөх чиглэлээр хийсэн мэдээлэл, сурталчилгааны | Үйл ажиллагааны тайлан | ЭМЯ<br>НЭМҮТ<br>Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд<br>Аймаг, нийслэлийн ЭМГ | ТББ<br>ОУБ<br>Хэвлэл мэдээллийн байгууллага | 2017-2020 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | материал, үйл ажиллагаа | | | | |
| 4.10 | Зорилтот бүлэг болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан мэдээлэл, сурталчилгааг хөгжүүлэх; | Мэдээлэл сургалт сурталчилгааны материал, гарын авлага<br>Зохион байгуулсан үйл ажиллагаа | Үйл ажиллагааны тайлан | НЭМҮТ<br>Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд<br>Аймаг, нийслэлийн ЭМГ | ХНХЯ<br>ТББ<br>ОУБ | 2017-2020 |
| 4.11 | Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчнөөс сэргийлэх, түүнд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийг бууруулах арга хэмжээг хүн амын бүлгүүд түүний дотор эрсдэлт бүлэгт тэгш хүртээмжтэй байхаар төлөвлөж хэрэгжүүлэх; | Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчнөөс сэргийлэх, түүнд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийг бууруулах чиглэлээр хийсэн үйл ажиллагаа | Үйл ажиллагааны тайлан<br>Гарсан тушаал, шийдвэр | НЭМҮТ<br>Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд<br>Аймаг, нийслэлийн ЭМГ | ОУБ<br>ТББ<br>Хэвлэл мэдээллийн байгууллагууд | 2017-2020 |

**Зорилт 5.** Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнууд болон тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн хүйсийн тэнцвэрт харьцааг зохистой болгох хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх

**Хүрэх үр дүн**

Эрүүл мэндийн салбарт ажиллагчдын хүйсийн зохистой харьцааг бий болгох эрх зүйн зохицуулалт хийгдэж, хэрэгжсэн байна.

| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Хэрэгжих хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| 5.1 | Эрүүл мэндийн чиглэлээр их дээд сургууль, коллежед элсэгчдийн хүйсийн зохистой байдлыг хангахад чиглэсэн ухуулга нөлөөллийн ажлыг БСШУСЯ-тай хамтран зохион байгуулах | Ухуулга нөлөөллийн уулзалт, хэлэлцүүлэг | Үйл ажиллагааны тайлан | ЭМЯ<br>АХБ-ны ЭМСХХ төсөл | БСШУСЯ | 2018-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5.2 | Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчдийн дийлэнх хувийг эзэлдэг эмэгтэйчүүдэд албан ажлаа ар гэрийн ажилтайгаа хослуулах боломжийг бүрдүүлэх, хүүхэд хөхүүлэх өрөө тохижуулах зэрэг жендэрийн мэдрэмжтэй зохицуулалтыг бий болгох | Жендэрийн мэдрэмжтэй зохицуулалтыг дотоод журамдаа тусган ажиллаж буй эрүүл мэндийн байгууллага | Гарсан тушаал, шийдвэр | Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд Аймаг, нийслэлийн ЭМГ | Аймаг, нийслэлийн ЗДТГ | 2017-2020 |
| 5.3 | Эрүүл мэндийн чиглэлийн хороо, зөвлөл, комисс, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөллийн эзлэх хувийг 30 хувиас дээш байх боломжийг судлан зохицуулалт хийж, хэрэгжүүлэх | Тушаал, шийдвэр | Гарсан тушаал, шийдвэрүүдэд хийсэн хяналт, үнэлгээ | ЭМЯ | Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд Аймаг, нийслэлийн ЭМГ | 2017-2020 |
| 5.4 | Ажиллагсдын хүйсийн тэнцвэрт харьцааг зохицуулах хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх ажлыг эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг дүгнэх шалгуур үзүүлэлтэд тусган хэрэгжүүлэх | Тушаал, шийдвэр | Үйл ажиллагааг дүгнэх үнэлгээний хэсэгт холбогдох шалгуур үзүүлэлтүүд орсон байна. | ЭМЯ | Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд Аймаг, нийслэлийн ЭМГ | 2018-2020 |

**Зорилт 6.** Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч, гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхийг дээшлүүлж, үйлчилгээг ээлтэй болгох
**Хүрэх үр дүн** Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын жендэрт суурилсан хүчирхийлллээс урьдчилан сэргийлэх, үйлчилгээ үзүүлэх чадавхи бэхжиж, үйлчилгээний чанарт ахиц дэвшил гарч, бусад оролцогч байгууллагатай хамтын ажиллагаа өргөжсөн байна.

| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Хэрэгжих хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| 6.1 | АШУҮИС болон эрүүл мэндийн нийгмийн | Үнэлгээ Зөвлөмж | Үйл ажиллагааны тайлан | ЭМЯ НҮБХАС | АШУҮИС ТББ | 2017-2019 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ажилтнуудыг бэлтгэдэг их сургуулиудын сургалтын хөтөлбөрт жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх сэдвийг сургалтын хөтөлбөрт оруулах, хичээлийн хэрэглэгдэхүүнийг боловсруулах, багш нарыг сургаж бэлтгэх | Хэлэлцүүлэг | Сургалтын хөтөлбөрт тусгагдсан сэдэв, агуулга, хөтөлбөр | | ОУБ | |
| 6.2 | Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдод эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйлчилгээ үзүүлэгчдийн мэдлэг, ойлголт чадварыг дээшлүүлэх сургалт, семинар, туршлага солилцох уулзалтууд зохион байгуулж, бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах | Сургагдсан эрүүл мэндийн ажилтнууд | Сургалт, үйл ажиллагааны удирдамж, төсөв, сургалтын хөтөлбөр<br><br>Зохион байгуулсан сургалтын тайлан<br><br>Сургагдсан хүний тоо | ЭМЯ<br>Аймаг, нийслэлийн ЭМГ<br>Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд | НҮБХАС | 2017-2020 |
| 6.3 | Хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн үйлчилгээ үзүүлэгчдийг чадавхижуулах, төвийн тохижилтийг сайжруулах, үйлчилгээний стандарт, журмыг боловсронгуй болгох | Сургагдсан эрүүл мэндийн ажилтнууд<br><br>Үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйл ажиллагаа явуулж буй Нэг цэгийн үйлчилгээний төв | Сургалт, үйл ажиллагааны удирдамж, төсөв, сургалтын хөтөлбөр<br><br>Зохион байгуулсан сургалтын тайлан<br><br>Сургагдсан хүний тоо<br><br>Нэг цэгийн | ЭМЯ<br>ГССҮТ<br>Аймаг, нийслэлийн ЭМГ | ХЗДХЯ<br>ХНХЯ | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | үйлчилгээний төвийн үйл ажиллагаа, санхүүжилтийн талаар гарсан тушаал, шийдвэр | | | |
| 6.4 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эрүүл мэндийн салбарын дүрэм, журмыг боловсруулан батлуулж, хэрэгжилтэд хяналт тавих | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн хэрэгжилт | Эрүүл мэндийн сайдын тушаал, журам | ЭМЯ<br>ГССҮТ<br>Аймаг, нийсэлийн ЭМГ | ХЗДХЯ<br>ХНХЯ<br>Холбогдох яамд | 2017-2020 |
| 6.5 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох ажилтан, үйлчилгээ үзүүлэгчдэд хууль, дүрэм журмыг хэрэгжүүлэх чиглэлээр сургалт, мэдээллийн үйл ажиллагаа явуулах | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн талаар хийсэн сургалт, сурталчилгааны ажил | Үйл ажиллагааны тайлан<br><br>Хамрагдсан эмч, мэргэжилтний тоо | ЭМЯ<br>Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд<br>Аймаг, нийсэлийн ЭМГ | ХЗДХЯ<br>Холбогдох яамд | 2017-2020 |

...............oOo...............